



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 10 сарын 05 өдөр

Дугаар А/544

Увсөнбулаг

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.2 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.4 дэх заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 10, 11 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг, "Шинэ сэргэлтийн бодлого" зорилтыг танилцуулах, 2020-2024 оны аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, орон нутгийн хөгжлийн сангаар хэрэгжүүлэх, төсөл хөтөлбөрт иргэдийн санал санаачлагыг сонсож тусгах, малчдад төрийн үйлчилгээг хүртээмжтэй хүргэх арга хэмжээг зохион байгуулан ажиллах ажлын хэсгийн хоол, бусад үйлчилгээний ажлыг гэрээ байгуулан гүйцэтгүүлэх эрхийг Засаг даргын Тамгын газар (Ш.Эрдэнэбат)-т олгосугай.

2. Шаардагдах 16,200,000 (арван зургаан сая хоёр зуун мянга) төгрөгийг хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ш.Эрдэнэбат)-т зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Э.Пүрэвжав)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР

C:\Documents\ ZD A-4 doc

0201090997

